## НИЙСЛЭЛИЙН ЦАХИМ ХӨГЖИЛ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗАР

## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

| ЗДҮАХ-т тусгагдсан зорилт | Дугаар | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Эх үүсвэр | Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг) | Суурь түвшин | Зорилтод | | | Хэрэгжилт | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Төсөв (Сая.төг) | Төсвийн Гүйцэтгэл (сая.төг) | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| **ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | | | | | | | | | | | | |
| 4.1 Мэдээллийн технологийн ухаалаг шийдлүүдийг ашиглан хотын цогц үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, нээлттэй, чирэгдэлгүй хүргэдэг ухаалаг хотыг бий болгоно. | 4.1.3 | 4.1.3.1 Харилцаа холбоо, мэдээллийн дэвшилтэт технологийг ашиглан иргэн төвтэй, ухаалаг үйлчилгээг үзүүлэх "Цахим засаглал" хөтөлбөр" хэрэгжүүлнэ. | 2022-2024 | НЦХМТГ | Нийслэлийн төсөв | 15,000.0 | Цахим засаглал төслийн хэрэгжилт 20%-д хүрсэн байна. | Цахим засаглал төслийн хэрэгжилт 70%-д хүрсэн байна. | 13,000.0 | - | Иргэн төвтэй ухаалаг үйлчилгээг үзүүлэх "Цахим Засаглал" хөтөлбөрийн хүрээнд:<br>- Нийслэлийн төрийн өмчит ЕБ-ын 285 сургуулиас 40 сургуульд E-school боловсролын нэгдсэн платформыг бүрэн хэрэглээнд нэвтрүүлж 40 ш киоск төхөөрөмж, сурагч бүрт сурагчийн карт буюу 110,000 орчим сурагчийн үнэмлэхийг олгосон. Тус платформыг сургуулийн удирдлагууд, 3901 багш, ажилтан, 104,485 сурагч эцэг эх өдөр тутамдаа ашиглаж байна.<br>- Нийслэлийн 9 дүүргийн 204 хорооны 1672 хэсгийн ахлагчийн үйл ажиллагааг цахимжуулахаар "Хэсгийн ахлагчийн систем"-ийг хэрэглээнд нэвтрүүлсэн бөгөөд системээр дамжуулан орчны 320 чиглэлээр зөрчил мэдээлэх, мэдээлэл хүргэх ажиллагааг зохион байгуулж байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 1,028 зөрчил бүртгэснээс шийдвэрлэсэн 958, шийдвэрлэх шатандаа 70 зөрчил байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 8 хоног 22 цаг 51 минут байна. | 70% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | - Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн ачааллын цагийг тэнцвэржүүлэх,эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг авахдаа цагийн зохион байгуулалтыг оновчтой хийх боломжтой "Ухаалаг цаг захиалгын систем" буюу 140 ширхэг ухаалаг цаг захиалгын киоск машин дэлгэц нийслэлийн 9 дүүргийн Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд суурилуулахаас эхний ээлжинд СБД-ийн 16, СХД-ийн 18 өрхийн эрүүл мэндийн төвүүдэд 100% суурилуулаад байна. Цаашид үлдсэн 8 дүүргийн өрхийн эрүүл мэндийн төвүүдэд үе шаттайгаар суурилуулахаар төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. | |
| | 4.1.1 | 4.1.1.3. Тоон гарын үсгийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хэрэглээнд бүрэн нэвтрүүлж, албан бичгийн харилцааг бүрэн цахимжуулна. | 2021-2024 | НЗДТГ | Нийслэлийн төсөв | 80.0 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд тоон гарын үсгийн хэрэглээг нэвтрүүлж, тамга тэмдэг, гарын үсэг зурах эрх бүхий 3,610 албан хаагчид тоон гарын үсгийн э-токен төхөөрөмж олгосон. | Тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлж, албан бичгийн харилцааг 90% цахимжуулсан байна. | 30.0 | - | Албан хэрэг хөтлөлт, архивын өдөр тутмын үйл ажиллагааг цахим хэлбэрт хөтлөн явуулах, хянах, удирдах, нэгдсэн арга зүйгээр хангах зорилгоор архив, албан бичиг хөтлөлтийн https://edoc.ulaanbaatar.mn/ системийг ашиглан нийслэлийн нутгийн захиргааны 996 байгууллагын 14077 албан хаагч тамга тэмдэг дарах эрх бүхий албан тушаалтны тоон гарын үсгээр албан бичиг илгээж солилцдог бөгөөд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын хоорондын албан бичгийн харилцааг 100% цахимжуулсан. | 100% |
| | 4.1.1 | 4.1.1.4. Төрийн албан хаагчийн цахим боловсрол, хандлагыг сайжруулж, **засаглалын уламжлалт үйл ажиллагаанд процессын** | 2022-2024 | НЗДТГ | Нийслэлийн төсөв | 250.0 | Бүх шатны нутгийн захиргааны байгууллага албан хаагчид мэдээлэл харилцаа холбооны технологийн зохистой ёс зүйтэй хэрэглээг төлөвшүүлэ | Мэдээлэл харилцаа холбооны технологийн зохистой ёс зүйтэй хэрэглээг төловшүүлэхэд шаардлагатай процессыг дахин загварчилж сургалтын | 100.0 | - | Иргэн, аж ахуйн нэгж байгууллага нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтантай уулзах цаг захиалах, өргөдөл гомдол, санал хүсэлт гаргах, талархал илэрхийлэх боломж бүхий QR систем нэвтрүүлэхээр хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлон техникийн даалгаврыг боловсруулж нийслэлийн дотоод удирдлагын UBERP | 90% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **дахин загварчлал хийнэ.** | | | | | х шаардлагатай байна. | стандартыг боловсруулна. | | | системийн нэг модуль болгон хөгжүүлэлтийн ажлыг хийж байгаа бөгөөд иргэд болон төрийн байгууллагууд, албан хаагчдад нийтээр болон тусгайлан мэдэгдэл хүргэх, гомдол, хүсэлт, санал гаргах, талархал илэрхийлэх боломж бүхий QR кодыг нийслэлийн бүх шатны албан хаагч бүрт үүсгэж бэлэн болсон. | |
| Нийслэлийн мэдээллийн сан, өгөгдлийн бүрэн байдал, аюулгүй байдлыг хангаж, нэг эх сурвалж бүхий мэдээлэл, нээлттэй өгөгдлийг бий болгоно. | 4.1.3 | 4.1.3.2 Улаанбаатар хотын алслагдсан гэр хороолол болон хүн ам ихээр цуглардаг тодорхой бүсүүдийг үе шаттайгаар утасгүй интернетжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2021-2024 | НМТГ | Нийслэлийн төсөв | 300.0 | Нийслэлийн хэмжээнд утасгүй сүлжээний хүртээмжийг нэмэгдүүлэх, алслагдсан гэр хороолол амралт зугаалгын газар болон хүн ам ихээр цуглардаг бүсүүдэд интернет үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх техникийн даалгавар боловсруулагдаж, нэгдсэн байдлаар зохион байгуулах төлөвлөгөө гаргасан байна. | Алслагдсан гэр хорооллын нэн шаардлагатай 20 цэгийг интернэтийн утасгүй сүлжээнд холбосон байна. | 160.0 | - | Нийслэлийн хэмжээнд хүн ам ихээр төвлөрдөг номын сан, амралт зугаалгын бүсийн судалгааг гаргаж нийт 20 цэг "Богд хааны ордон музей, Гандантэгчилэн хийд, УБ төмөр замын буудал, Хүүхдийн урлан бүтээх төв, Жуковын хөшөө, музей, Монгол цэргийн музей, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, Улсын төв номын сан, Улсын төв номын сангийн салбарууд, Налайх дүүргийн Соёлын ордон Багахангай дүүргийн соёлын ордон"-т шинээр утасгүй интернетийн үйлчилгээг хүргэхээр тоног төхөөрөмжийн тооцоо судалгаа техникийн даалгавар боловсруулагдсан бөгөөд 2023 оны нийслэлийн төсөвт санал хүргүүлсэн боловч төсөв батлагдаагүй. | 50% |
| 4.2 Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно. | | | | | | | | | | | | |
| Нийслэлийн нутгийн захиргааны болон нийслэлийн өмчит, аж ахуйн тооцоот байгууллагуудын чиг үүргийн давхардал, | 4.2.1 | 4.2.1.2 нийслэл хотод үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны зөвшөөрлийн тоог | 2021-2024 | НЗДТГ | Нийслэлийн төсөв | - | Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа цахимжуулах ажлын хэрэгжилт 5 хувьд хүрсэн байна. | Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулах ажлын хэрэгжилт 10 хувьд хүрсэн байна. | - | - | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагад үзүүлдэг Төрийн үйлчилгээний операторын болон нэгдсэн портал www.e-mongolia.mn системийн дэд систем болох Бизнесийн орчин дахь төрийн үйлчилгээг цахимжуулах "E-Business" платформд нийслэлийн "Онлайн бизнес төв"-өөр үзүүлж буй бизнес эрхлэгчдэд | 70% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| үйл ажиллагаан ы хийдлийг арилгаж, захиргааны төвлөрлийг сааруулж, бүтэц зохион байгуулалты г оновчтой, цомхон болгоно. | | цөөрүүлж, зөвшөөрөл олгох нөхцөл журмыг тодорхой ойлгомжтой болгон цахимжуулж, хяналт шалгалтыг цөөрүүлнэ. | | | | | | | | | зориулсан нийслэлийн нутгийн захиргааны 15 байгууллагын 134 үйлчилгээг холбосон. 2023 оны эхний хагас жилийн байдлаар Онлайн бизнес төвийн "Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем"-д 453,466 иргэн, аж ахуй нэгж байгууллага хандаж 12,755 хүсэлтийг ирүүлснээс 8,471 хүсэлтийг зөвшөөрсөн болон батлуулахаар шилжүүлсэн төлөвтэй буюу үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөө аваад байна.<br>Мөн нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас бизнес эрхлэгч иргэн аж ахуйн нэгжид олгодог зөвшөөрөл болон зөвшөөрлийн шинжтэй 100 үйлчилгээг 2023 онд цахимжуулахаар техникийн даалгаврыг боловсруулсан бөгөөд хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах Эрх шилжүүлэх НЗД-ын захирамж гараагүй хүлээгдэж байна. | |
| Гудамж, зам талбайг хянах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хулгайлах гэмт хэрэг үйлддэг этгээдүүдийн мэдээллийн сангийн ашиглалтыг сайжруулж, камерын хяналтын нэгдсэн системийг байгуулан, гэмт хэргийн гаралтыг бууруулна. | 4.3.1 | 4.3.1.1 Нийслэлийн удирдлага, хяналт, зохицуулалт ын нэгдсэн системийг байгуулж, хэрэглээнд нэвтрүүлнэ. | 2022-2024 | НЗДТГ, НМТГ, НАЗХГ, ЗИХТЗИГ | Нийслэл ийн төсөв | - | Нийслэлийн удирдлага, хяналт зохицуулалт ын нэгдсэн системийн техникийн даалгавар боловсруул агдсан байна. | Нэгдсэн системийг байгуулах ажлын хэрэгжилт 30 хувьд хүрсэн байна. | - | - | Нийслэлийн удирдлага, хяналт, зохицуулалтын нэгдсэн системийн дэд систем болох нийслэлийн удирдлагуудыг бодитой хэмжигдэхүйц мэдээ мэдээллээр шуурхай хангах удирдлагын үйл ажиллагааг ухаалагаар удирдан зохион байгуулах боломжийг олгох "Сити дашбоард"-ын техникийн даалгаврыг боловсруулж салбар тус бүрээр ангилан дараах 11 төрлийн мэдээллийг агуулсан дашбоардыг хөгжүүлж нийслэлийн мэдээ, мэдээллийн www.ulaanbaatar.mn цахим хуудастай холбосон. Үүнд:<br>1. Хэсгийн ахлагч<br>2. Боловсрол<br>3. Өргөдөл, гомдол<br>4. Аюулгүй байдал – 3 дашбоард<br>5. Хөрөнгө оруулалт<br>6. Санхүү төсөв<br>7. Онлайн бизнес төв | 90% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | 8. Зам, тээвэр<br>9. Орон зай<br>Тус дашбоардад хариуцсан чиг үүргийн 11 байгууллага 14 хоног тутам мэдээ, мэдээллээ шинэчилж оруулах бөгөөд нийслэлийн удирдлагуудыг мэдээллээр хангах, цаашдын төлөвлөлтийг оновчлох зэрэг ач холбогдолтой юм. | |
| | 4.3.1 | 4.3.1.2 Бичлэг болон зурган мэдээллээс үл давтагдах өгөгдлөөр программ хангамжийг нэвтрүүлэх, гэмт хэргийн цахим зураглалыг цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох ажлуудыг хийж, камерыг "Камерын удирдлагын нэгдсэн төв"-тэй холбоно. | 2022-2024 | НЗДТГ, НМТГ | Нийслэлийн төсөв | - | Телекамер, замын хөдөлгөөний удирдлагын системийн техникийн даалгавар боловсруулагдсан байна. | Шинээр суурилуулсан 500 камер холбосон байна. | - | - | Нийслэлийн хэмжээнд 2019 - 2022 онуудад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 920 цэгийн 3240 камерын 95 ширхэг техникийн даалгавар, шийдлийг нутгийн захиргааны байгууллагуудад хүргүүлсэн ба нийт 232 камерыг Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын төвийн нэгдсэн камерын системд холбохоор төлөвлөн ажиллаж байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар 500 орчим камер суурилуулах 24 камерын техникийн даалгавар болон шийдлийг боловсруулж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. | 70% |
| **ЗУРГАА. НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | | | | | |
| 6.3 Улаанбаатар хотын хөгжлийг хангасан, стандартад нийцсэн инженерийн дэд бүтцийг хөгжүүлж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, иргэдийн ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ. | | | | | | | | | | | | |
| Нийслэл хотын замын хөдөлгөөн, тээврийн ухаалаг систем теслийг бүрэн хэрэгжүүлнэ. | 6.3.11 | 6.3.11.3 Замын хөдөлгөөнийг удирдах, хянах, бүртгэх, үйл ажиллагааны нэгдсэн ухаалаг дэд системүүдийг нэвтрүүлнэ. | 2020-2024 | НМТГ, ЗХУТ, НЗХТЗИГ, НХБХГ, НГЗБА | Нийслэлийн төсөв | - | Нийслэлийн хэмжээнд замбараагүй 30-аад төрлийн систем байгаа бөгөөд албан ёсны VMS AS байхгүй стандартын шаардлага хангасан камер, дутмаг одоогийн байдлаар | Дэд системүүдийн хэгжүүлэлтийн ажил 50 хувьд хүрсэн байна. | - | - | Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/207 дугаар захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2023 онд "Зам, тээврийн нэгдсэн систем"-ийн ажлын хүрээнд хэрэгжүүлэх Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ /RFID tag/-г суурилуулах ажлын тендерийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгчээр шалгарсан компанитай гэрээ байгуулсан бөгөөд нийслэлийн хэмжээнд 100 цэгээр дамжуулан 442477 ширхэг цахим гэрчилгээг тээврийн хэрэгсэлд 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн | 70% |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | камер байгаа ч нэгдсэн хяналт, арчлалт үйлчилгээ, хоорондын уялдаа холбоо байхгүй байна. | | | | суурилуулахаар төлөвлөж байна. | |
| Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөнөөс байгууллагад хамаарах 2 зорилтын 8 заалт, арга хэмжээний хэрэгжилт 2023 оны 1-р улирлын байдлаар:<br>100 хувьтай хэрэгжсэн 1 арга хэмжээ,<br>90 хувьтай хэрэгжсэн 2 арга хэмжээ<br>70 хувьтай хэрэгжсэн 4 арга хэмжээ<br>50 хувьтай 1 арга хэмжээ байна. **ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ: 76.2 %** | | | | | | | | | | | | **76.2%** |

ТАНИЛЦСАН:

ДАРГА О.ЧИНЗОРИГ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.ЭНХЗУЛ

НЭГТГЭСЭН:

ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Б.АРИУНЗАЯА

## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ 2023 ОНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЙЛАН

| Дугаар | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Үндсэн хэрэгжүүлэх байгууллага | Суурь түвшин | Зорилтод түвшин | Хүрсэн түвшин | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | | | | | | | |
| 4.1 Мэдээллийн технологийн ухаалаг шийдлүүдийг ашиглан хотын цогц үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, нээлттэй, чирэгдэлгүй хүргэдэг ухаалаг хотыг бий болгоно. | | | | | | | |
| ЗДҮАХ 4.1.3.1 | "Цахим засаглал хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн хувь | хувь | НЦХМТГ | Цахим засаглал төслийн хэрэгжилт 20%-д хүрсэн байна. | Цахим засаглал төслийн хэрэгжилт 70%-д хүрсэн байна. | 70 | 70% |
| ЗДҮАХ 4.1.1.3 | Тоон гарын үсгийг хэрэглээнд бүрэн нэвтрүүлж, албан бичгийн харилцааг бүрэн цахимжуулалт | хувь | НЗДТГ | - | 70 | 100 | 100% |
| ЗДҮАХ 4.1.1.4 | Төрийн албан хаагчийн цахим боловсрол, хандлагыг сайжруулж, засаглалын уламжлалт үйл ажиллагаанд процессын дахин загварчлал хийнэ. | хувь | НЗДТГ | - | 70 | 90 | 90% |
| ЗДҮАХ 4.1.3.2 | Апслагдсан гэр хороололд утасгүй интернэтийн сүлжээнд холбосон цэг | тоо | НМТГ | 154 | 174 | 50 | 50% |
| 4.2 Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц, зохион байгуулалтыг оновчтой, цомхон болгоно. | | | | | | | |
| ЗДҮАХ 4.2.1.2 | Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны цахимжуулалт | хувь | НЗДТГ<br>НМТГ | 0 | 10 | 70 | 70% |
| 4.3 Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана. | | | | | | | |
| ЗДҮАХ 4.3.1.1 | Нэгдсэн систем байгуулах ажлын хэрэгжилт | хувь | НЦУГ<br>НМТГ | 18 | 30 | 90 | 90% |
| ЗДҮАХ 4.3.1.2 | Удирдлагын нэгдсэн төвд холбогдсон камер | тоо | НЦУГ<br>НМТГ | 415 | 1,415 | 500 | 70% |
| **ЗУРГАА. НИЙСЛЭЛ БА БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| 6.3 Улаанбаатар хотын хөгжлийг хангасан, стандартад нийцсэн инженерийн дэд бүтцийг хөгжүүлж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, иргэдийн ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ. | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **ЗДҮАХ 6.3.11.3** | Нийслэл хотын замын хөдөлгөөн, тээврийн ухаалаг системд хамрагдалтын хувь | Хувь | НЗХТЗИГ<br>НМТГ<br>ЗХУТ | - | 25 | 70 | 70% |
| Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2023 оны төлөвлөгөөнөөс байгууллагад хамаарах 2 зорилтын 8 заалт, арга хэмжээний хэрэгжилт 2023 оны 1-р улирлын байдлаар:<br>100 хувьтай хэрэгжсэн <u>1</u> арга хэмжээ,<br>90 хувьтай хэрэгжсэн <u>2</u> арга хэмжээ<br>70 хувьтай хэрэгжсэн <u>4</u> арга хэмжээ<br>50 хувьтай <u>1</u> арга хэмжээ байна. **ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ: 76.2 %** | | | | | | | **76.2%** |

ТАНИЛЦСАН:
ДАРГА О.ЧИНЗОРИГ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.ЭНХЗУЛ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Б.АРИУНЗАЯА

БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТЭНД ХИЙСЭН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ АЖЛЫН ТАНИЛЦУУЛГА

2023 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Улаанбаатар хот

1.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Бодлогын баримт бичиг болох Нийслэлийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт, шинжилгээ хийх, гүйцэтгэлийг тавьсан зорилтот түвшинтэй харьцуулан хэрэгжилтийн түвшинг тогтоон үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв бодитой мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

2. ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Хяналтанд авсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374 дүгээр тогтоолоор шинэчлэн батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг удирдлага болгосон.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хэлтсүүдээс ирсэн тайланд үнэлгээ хийж биелэлтийг хувиар тодорхойлж үнэлгээг гаргав.

3. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 5 зорилтын 8 арга хэмжээний хэрэгжилт **76,2**% байна.

| № | Зорилт | Арга хэмжээ | Арга хэмжээний хэрэгжилт хувиар | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 100 | 90 | 70 | 50 | 30 |
| 1 | Мэдээллийн технологийн ухаалаг шийдлүүдийг ашиглан хотын цогц үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй, нээлттэй, чирэгдэлгүй хүргэдэг ухаалаг хотыг бий болгоно. | 3 | 1 | 1 | 1 | | |
| 2 | Нийслэлийн мэдээллийн сан, өгөгдлийн бүрэн байдал, аюулгүй байдлыг хангаж, нэг эх сурвалж бүхий мэдээлэл, нээлттэй өгөгдлийг бий болгоно. | 1 | | | | 1 | |
| 3 | Нийслэлийн нутгийн захиргааны болон нийслэлийн өмчит, аж ахуйн тооцоот байгууллагуудын чиг үүргийн давхардал, үйл ажиллагааны хийдлийг арилгаж, захиргааны төвлөрлийг сааруулж, бүтэц зохион | 1 | | | 1 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулалтыг оновчтой, цомхон болгоно. | | | | | | |
| 4 | Гудамж, зам талбайг хянах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хулгайлах гэмт хэрэг үйлддэг этгээдүүдийн мэдээллийн сангийн ашиглалтыг сайжруулж, камерын хяналтын нэгдсэн системийг байгуулан, гэмт хэргийн гаралтыг бууруулна. | 2 | | 1 | 1 | | |
| 5 | Нийслэл хотын замын хөдөлгөөн, тээврийн ухаалаг систем төслийг бүрэн хэрэгжүүлнэ. | 1 | | | 1 | | |
| | **Нийт үнэлгээ** | 8 | 1 | 2 | 4 | 1 | - |

4. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ

Нийслэлийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт, шинжилгээ үнэлгээ хийхэд зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдсэн.

2023 онд хэрэгжүүлэх 1 төсөл арга хэмжээ жил бүрийн нийслэлийн төсөвт санал хүргүүлдэг боловч төсөв баталдаггүй.

Үүнтэй холбогдуулан утасгүй интернетийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах санал хүргүүлсэн ч хамтран ажиллах боломжгүй гэсэн албан ёсны хариу өгсөн байна.

5. ЗӨВЛӨМЖ

1. Төсөв батлагдаагүй арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг хангах чиглэлээр дотоод нөөц бололцоогоо ашиглан ажиллахад хариуцсан хэлтсүүд анхаарч ажиллах.

2. Албан хаагчид төсөл арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинг хангаж, үр дүнд суурилан тайлагнахад анхаарч тоо баримттай, үг үсгийн болон найруулгын алдаагүй, гарсан үр дүнг 2000 тэмдэгтэд багтаасан байх.

3. Хэлтсүүдээс гарч байгаа тайланг хэлтсийн дарга нараар хянуулж, эцсийн байдлаар тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгөх

4.Дээр дурдсан зөвлөмжүүдийг цаашид анхаарч, хэрэгжүүлж ажиллахыг нийт албан хаагчдад үүрэгжүүлэх.

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ЗТСХ-ИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.ЭНХЗУЛ